



# Дүн шинжилгээ хийх арга зүй

А.Алтанзул

# Бодлогын үнэлгээний төрөл

- Ex ante evaluation:  
Бодлого хэрэгжүүлэхээс өмнөх үнэлгээ
- Ongoing evaluation:  
Бодлогын хэрэгжилтийн явц дахь үнэлгээ
- Ex post evaluation:  
Бодлого хэрэгжилтийн дараах үнэлгээ
- *Relevance*: do we want to go from A to B ?  
(need versus objective)
- *Effectiveness*: do we meet our objective (do we arrive at B)?
- *Efficiency*: at what cost do we arrive at B?







# Үр нөлөөний үнэлгээний шинж

- Үнэлгээ нь **ҮР ДҮНГ** хэмждэг, гэхдээ мэргэжилтэн нь өөрийн үзэмжээр буюу баримталдаг хэм хэмжээ, үнэ цэнийн хүрээнд **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**ийг сонгодог
- Нэг хуулийн төслийн **үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо** үнэлгээний багийн гишүүд нь мэргэжлээсээ шалтгаалан (эдийн засагч, сэтгэл зүйч, нийгэм судлаач, улс төр судлаач г.м.) харилцан адилгүй байдлаар хандаж болно

# ҮНЭЛГЭЭ ЮУ ХЭМЖИДЭГ ВЭ?

- **Үр дүн\нөлөө**: тухайн хуулийн төслийн үр дүнгээ өгч байна уу (?)
- **Үр ашиг**: хуулийн төсөл хэрэгжүүлэх зардлын үр ашиг: өртөг-өгөөжийн эсвэл өртөг-үр ашгийн дүн шинжилгээ хийнэ
- Зарим хэмжигдэхүүн:
  - Тэгш байдал
  - Шудрага байдал
  - Сэтгэл ханамж

# ҮНЭЛГЭЭНД НӨЛӨӨЛӨГЧ

## 1. Үнэлгээг хэн хийж байна?

- *элитүүд* : Төрийн байгууллагууд, улсын их сургуулиуд, бодлогын (think tank) хүрээлэнгүүд
- *Сонирхолын бүлгүүд*
- *Иргэд* : Гомдол, нийгмийн байр суурь, эгүүлэн татах-хариуцлага нэхэх

## 2. Үнэлгээ ба хүнд суртлын хяналт

- Хуулийн зорилт үр дүнтэй байна уу?
- Хууль бодит амьдралд хэрэгжиж байна уу?
- Үнэлгээний үр дүнг танилцуулах нь судлаач биш хүмүүст ойлгомжгүй.
- Үнэлгээний үр дүн нь нийгэмд төлөвшсөн итгэл үнэмшлийн эсрэг, эсвэл түүнийг үгүйсгэдэг.
- Хуулийг хэрэгжүүлэхэд талууд өөр өөрийн ашиг сонирхолтой байдаг.

# Үр нөлөөний үнэлгээ хийх дизайн

## Зорилго:

- Хуулийн зорилтын үр дүн, үр нөлөөг тодорхойлдог
- Хууль гарсны үр дүнд тус уг хуулийн үр шим хүртэгчдийн мэдлэг, хандлага, зан байдалд гарах **өөрчлөлтүүдийг** хэмждэг
- Нийтлэг шинж чанарууд:
  - Ихэвчлэн **тоон** өгөгдлийг шаарддаг
  - Ихэвчлэн **статистикийн** нарийн арга техникийг шаарддаг
  - **Харьцуулах** бүлэг шаардаж магад(үр нөлөөний үнэлгээ)

# Шалтгаан, үр дагаварын үнэлгээ

- Туршилтын хэлбэртэй (experimental)
  - Сургууль завсардсан хүүхдүүд
- Хагас туршилтын (quazi-experimental)
  - Эрэгтэй эмэгтэй жолоочийн харилцааны соёл
- Туршилтын бус (non-experiment)
  - Дүрслэлт буюу тайлбарласан судалгаа (descriptive evaluations), /явцын/хэрэгжилтийн үнэлгээнд түлхүү ашиглагддаг
- Эдгээр чиг хандлагад нь янз бүрийн үе шат дахь олон төрлийн харьцуулалтыг ашиглах боломжтой

# Үр нөлөөний дүн шинжилгээ хийх зорилго ба асуулт

- Мэдээлэл цуглуулах – зорилтот бүлгүүдэд хүрч байгаа эсэхийг тогтоох асуултууд.
- Эгэх хариуцлага – хөрөнгө мөнгийн зарцуулалтыг тогтоох асуултууд
- зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, чанар ямар байгааг олж тогтоох.
- Хэрэгжилтийг сайжруулах – үйл явц зөв эсэх, хэрэгжилтийн үр дүнг хэмжих, хяналт шалгалт зохих түвшинд хийгдэж буйг шалгах.
- Гарц/Үр дүнгийн үнэлгээ – нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөг шинжлэх.
- Мэдлэг – хуулийн төслийн үр ашгийг шинжлэх

# Дүн шинжилгээ хийх асуултууд

“ЯМАР АСУУЛТАД ХАРИУЛТ АВАХ ГЭЖ БИД ЭНЭХҮҮ ДҮН ШИНЖИЛГЭЭГ ХИЙЖ БАЙНА ВЭ?”

- Асуултуудыг ангилах (үйл ажиллагаа, төлөв байдал, үр дүн г.м.)
- Асуултуудыг ач холбогдлоор нь **ЭРЭМБЭЛЭХ:**

“ЯАГААД ЭНЭ АСУУЛТЫГ АСУУЖ БАЙНА ВЭ?”

# ЖИШЭЭ 1: Хүүхэд хамгааллын тухай хууль

- **Хуулийн зорилт:** 1.1. Энэ хуулийн зорилт нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- **Шалгуур үзүүлэлт:**
  1. **Иргэдийн ерөнхий үнэлгээ:** хэрэгцээ шаардлагын судалгаанд иргэдээс хүүхэд хамгааллын асуудлыг “сайн/муу” үнэлгээ өгсөн тоог хүүхдийн эрх ашиг хохирсон цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлүүдийн тоотой харьцуулах
  2. **Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын хийсэн ажил:** эдгээр байгууллагуудын тайлан
  3. **Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын тоо:** нэг хүүхдэд ноогдох сургууль болон хорооны нийгмийн ажилтан болон төрийн бус байгууллагын тоог харьцуулах

Гэх мэт

# Тайлбарласан, хэрэгжилтийн үр дагаварт хийсэн асуултуудын жишээ

Бодит нөхцөл байдлыг тодорхойлох талаар:

- Бүртгүүлсэн сурагчдын тоо?
- Заасан хичээлийн тоо?
- Үйлчилгээ үзүүлэгч, үйлчлүүлэгчдийн тооны харьцаа?
- Нэг хүнд үйлчилгээ үзүүлэхэд гардаг зардал?
- Хамрагдвал зохих иргэдийн хэдэн %-д үйлчилгээ үзүүлсэн?

Үр дүнг тооцох талаар:

- Үйлчлүүлэгчдийн хэд нь ядуурлын түвшингээс дээгүүр амьжиргаатай иргэд байсан бэ?
- Ажлын байранд гарсан осол гэмтлийн тоо?
- Сурагчид стандарт шалгалтуудад ямар оноо авсан?

# Учир шалтгааны, хэрэгжилтийн үнэлгээний асуултуудын жишээ

- Ямар шалтгааны улмаас зарим байгууллагууд:
- Дүрэм журмыг чандлан биелүүлдэг вэ?
- Хэрэгжилтийг удаашруулдаг вэ?
- Илүү олон тооны үйлчилгээ үзүүлдэг вэ?

- ҮР ДҮНГГ ТООЦОХ ТАЛААР

- Хамгаалалтын бүс зүүх нь ослын улмаас нас барагсдын тоог бууруулах уу?
- Нэг ангид суралцагсдын тоо цөөн байх тусам сурлагын үзүүлэлт сайжрах уу?
- Сургалт зохион байгуулснаар ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлж, ажил эрхлэлтийн чанарыг сайжруулах уу?
- Ямар шалтгааны улмаас хүмүүс орон гэргүй болдог вэ?

# Учир шалтгааны үнэлгээ

- Зорилго – хөтөлбөрийн хэрэгжилт болон үр нөлөөний талаар нотолгоо бүхий учир шалтгааны мэдэгдэл хийх
- Харьцуулалт (cross section)– хөтөлбөр хэрэгжсэн болон хэрэгжээгүй байгууллагуудыг хооронд нь харьцуулах.
- Харьцуулалт (time – series) – тухайн байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжихээс өмнөх үе, дараах үеийг харьцуулах.
- ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ тодорхой нэгэн **шалтгаан/нөлөөллийн** асуултанд хариулт авахын тулд хийгддэг үнэлгээний арга

# Үр нөлөөний үнэлгээний асуултуудын жишээ

- Тэтгэлэгт хөтөлбөр нь сургуульд хамрагдалт болон сургалтын үр дүнд хэрхэн нөлөөлөх вэ?
- Сургуулийн өмнөх насны боловсролын үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээлэн гүйцэтгүүлэх нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжид ямар үр нөлөө үзүүлэх вэ?
- Шороон шалыг цементэн шалаар солих нь хүүхдүүдийн эрүүл мэндэд ямар үр нөлөө үзүүлэх вэ?
- Сайжруулсан зам барьснаар хөдөлмөрийн зах зээлийн хүртээмж сайжирч, өрхийн орлого нэмэгдэх үү? Тийм бол хэдий хэмжээгээр нэмэгдэх вэ?
- Нэг ангид суралцах хүүхдийн тоо нь сурлагын үр дүнд нөлөөлөх үү? Тийм бол хэдий хэмжээгээр нөлөөлөх вэ?

## Шалгуур үзүүлэлтүүдийн төрөл

- **БҮТЭЭГДЭХҮҮНИЙ** үзүүлэлтүүд: үргэлжлэх хугацаа, хэмжээ, талбай, ур чадвар, сургасан байдал, зөвлөгөө өгсөн байдал
- **ҮР НӨЛӨӨНИЙ** үзүүлэлтүүд: цаг хугацаа хэмнэсэн байдал, үнийн бууралт, шинэ үйлчилгээ, үйлчилгээний сэтгэл ханамжийн байдал
- **Урт хугацааны үр нөлөөний үзүүлэлтүүд:** үүсгэн байгуулагдсан компаниудын оршин тогтнох чадвар, хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараахи ажлын байрны хадгалалт, хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ

# Шалгуур үзүүлэлт сонгох үед нөлөөлөх хүчин зүйл

- Асуудал, бодлоготой логик уялдаа
- Шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл үү
- Эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагад нийцэж байгаа эсэх
- Өгөгдөл нь олдох боломжтой эсэх
- Стандартчилагдсан индикатор уу
- Тоон
  - Сургалтад хамрагдсан тоо
  - Төрийн үйлчилгээг хүртсэн иргэдийн тоо
- Тооцоолсон: жин, хувь, харьцаа
  - Эрэгтэйчүүдийн сургалтад хамрагдагсдын эзлэх хувь
  - Төрөл, нас баралтын харьцаа,
- Индекс, нийлмэл хэмжигдэхүүн
  - Чанарын индекс /чанарын 6-н үзүүлэлтийг нэгтгэсэн үзүүлэлт/
  - ХБИДН (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дундаж наслалт)
- Түвшин /заагласан хэмжигдэхүүн/
  - Эерэг, сөрөг, байна, байхгүй
  - Урьдчилан тодорхойлсон түвшин, стандарт

# Шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах/хэрэглэх матриц

Шалгуур үзүүлэлт	Мэдээл-лийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга	Хэн мэдээлэл цуглуулах	Мэдээлэл цуглуулах давтамж	Мэдээлэл цуглуулах зардал	Цуглуулахад гарах бэрхшээл	Мэдээлэл хэн дүн шинжилгээ хийх, тайлагнах	Мэдээллийг хэрэглэх
------------------	-----------------------	-------------------------	------------------------	----------------------------	---------------------------	----------------------------	--	---------------------

1.

2.

3.

4.

## Мэдээлэл цуглуулах арга

Эх сурвалж	Үйлдэл
Мэргэжлийн шинжээчдийн дүгнэлт	Тухайн хуулийн төслийн хүрээнд дотоодын мэргэшсэн хуульчид, эдийн засагчид, шинжээчдээс санал, дүгнэлт авах
Төрийн эрх бүхий байгууллагын гаргасан тоон мэдээлэл	Ялангуяа энэ хэсэгт зардал –үр ашгийн шинжилгээг гаргуулах , Сангийн яам, Статистикийн хорооны тайлан, тоон мэдээлэл
Олон улсын байгууллагуудаас гаргасан тоон судалгаа болон гадаад улс орнуудын туршлага	Гадаад улс орнуудын сайн туршлагыг судлах, Дэлхий банк, OECD-ийн гаргасан тайланг судлах
Олон нийтийн санал, үзэл бодлыг тандсан санал асуулга	Өмнө нь хийгдсэн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгаа болон шаардлагатай гэж үзвэл дахин иргэдээс тандан судалгаа авах
Нээлттэй хэлэлцүүлэг	Төрийн болон хувийн секторыг хамруулсан өргөн хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулах, цахим хаягт байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих
Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага	Хуулийн төслийн хүрээнд эрх ашиг хөндөгдөх этгээдүүдтэй уулзалт, ярилцлага хийх

# Хуулийн төслийг үнэлэх шалгуур ҮЗҮҮЛЭЛТ

## Шалгуур үзүүлэлтийн шаардлага:

- ❑ **Шууд** /Шалгуур үзүүлэлт нь хэмжих гэж буй үр дүнг аль болох шууд хэмжихүйц байх ёстой. Шууд хэмжих боломжгүй бол 1-2 орлох шалгуур үзүүлэлтийг хэрэглэх/
- ❑ **Энгийн** /хэмжиж буй зүйлийн талаар аливаа хоёрдмол санаа байхгүй байх/
- ❑ **Хангалттай** /Тухайн хэмжих гэж буй үр дүнг бүрэн хэмжих боломтой тооны шалгуур үзүүлэлтийг боловсруулах/
- ❑ **Тоогоор илэрхийлэгдэх** /Шалгуур үзүүлэлт нь тоон шалгуур үзүүлэлт байх. Тоогоор илэрхийлэх боломжгүй тохиолдолд тоо руу хөрвүүлэх боломжийг эрэлхийлэх. Боломжгүй тохиолдолд чанарын шалгуур үзүүлэлт боловсруулах /

## Хуулийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт

- ❑ **Ангилалгдах** - БОЛОМЖТОЙ БОЛ АНГИЛСАН БАЙХ /Олон шалгуур үзүүлэлт боловсруулсан тохиолдолд ангилах. Ангилсан тоо баримт, мэдээлэл нь тухайн бүлгийг хамрах, ингэснээр үр дүн гарах эсэхийг тооцоолоход хэрэгтэй/
- ❑ **Бодитой байх** /Тоо баримт мэдээллийг цаг хугацаанд нь, боломжийн үнээр олж авах нь чухал/.
- ❑ **Найдвартай** /шийдвэр гаргагчдад энэхүү шалгуур үзүүлэлтээр хангалттай, чанартай тоо баримт мэдээллийг өгөх боломж байна уу гэдгийг анхаарна./

# Хуулийн төслийг үнэлэх шалгуур ҮЗҮҮЛЭЛТ

Зорилго, зорилтын боловсруулалтын чанарыг  
хэмжих шалгуур үзүүлэлт - **Томъёололд**

**Тав** Create S.M.A.R.T. Goals **гага:**



## Хуулийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт

### Зорилго, зорилтын томъёоллыг хэмжих шалгуур үзүүлэлт:

Хэмжих үзүүлэлт		Оноо	Хувь
Тодорхой	Зорилгын томъёолол ойлгомжтой /нэгдмэл, хоёрдмол утгагүй / эсэх	1-5	а%
Хэмжигдэхүйц	Зорилго, зорилтондоо хүрсэн эсэхийг хэмжих боломжтой эсэх	1-5	б%
Хүрч болохуйц	Зорилго, зорилтонд хүрэх арга зам нь тодорхой, хэрэгжүүлэх боломжтой эсэх	1-5	в%
Бодитой	Нөөц, чадавхитай уялдсан эсэх	1-5	г%
Цаг хугацаатай	- Хугацааны хязгаар тогтоосон эсэх -Хугацаа нь үр дүнг бий болгоход хангалттай эсэх	1-5	д%
<b>НИЙТ</b>		<b>25</b>	<b>100%</b>

# Хуулийн төслийг үнэлэх шалгуур ҮЗҮҮЛЭЛТ

Судалгаанд өргөн хэрэглэгддэг хамгийн хялбар тоон систем нь шкал юм.

- Шкал гэдэг нь чанарыг тоогоор илэрхийлэх зорилго бүхий, тухайн объект, субъект, төлөв байдлын тоон хэмжигдэхүүн
- Шкал нь ихэвчлэн нэг хэмжигдэхүүнтэй байдаг бөгөөд зөвхөн тухайн шинж чанар юмс үзэгдэлд хэр зэрэг илэрч байгааг хэмжих зориулалттай
- Шкалыг ихэвчлэн үзүүлэлтийн утга буюу онооны нийлбэрийг гаргах замаар бий болгодог бөгөөд ойлгоход хялбар дөхөм байдаг

# Хуулийн төслийг үнэлэх шалгуур ҮЗҮҮЛЭЛТ

## Лайкертийн шкал:

Лайкертийн шкал нь аливаа зүйлийг өөр хооронд нь харьцуулахгүйгээр тусгаарлан дүгнэдэг арга /техник/ бөгөөд тодорхой нэг байдлыг илэрхийлдэг

Лайкертийн шкалаар ихэвчлэн 5 түвшинд үнэлдэг ч зарим тохиолдолд 5-9 хүртэл түвшинд ангилдаг тохиолдол байдаг.



- 5 – Маш сайн**
- 4 - Сайн**
- 3 - Дунд зэрэг**
- 2 – Муу**
- 1 - Маш муу**



## Хуулийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт

### Шийдвэрийн төслийг үнэлэх ерөнхий **Шалгуур Үзүүлэлт:**

Хэмжих үзүүлэлт	Он оо	Хув ь
Тулгамдсан асуудлыг зөв тодорхойлсон байдал	1-5	а%
Асуудлыг шийдвэрлэх альтернатив хувилбарыг боловсруулсан байдал	1-5	б%
Бодлогын зорилго, зорилтын уялдаа, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийсэн байдал	1-5	в%
Боловсруулалтад оролцогч талуудыг оролцоог хангаж ажилласан байдал	1-5	г%
Төслийн агуулга, хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байдал	1-5	д%
Эрх зүйн үндэсийг тодорхойлсон байдал	1-5	е%
Эдийн засгийн /төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэр/ боломж	1-5	ё%
Нийгэм, соёлын боломж	1-5	ж%
Хэрэгжүүлдэх чадавхи	1-5	з%

# Шийдвэрийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Зорилго, зорилтын уялдааг хэмжих шалгуур үзүүлэлт:

Хэмжих үзүүлэлт	Оноо	Хувь
Бодлогын зорилго, зорилт нь дээд түвшний /урт болон дунд хугацааны/ бодлогын зорилго, зорилттой нийцсэн /уялдсан/ байдал	1-5	а%
Бодлогын зорилго, зорилт нь ижил түвшний бодлогын зорилго, зорилттой нийцсэн /уялдсан/байдал	1-5	б%
Бодлогын зорилго, зорилт нь хоорондоо нийцсэн /уялдсан/байдал	1-5	в%
<b>Нийт</b>	<b>15</b>	<b>100%</b>